



“АР СИ ЭС СИ” ХХК

УЛААНБААТАР ХОТ-16081. БАЯНГОЛ ДҮҮРЭГ, 5-Р
ХОРОО, 10-Р ХОРООЛОЛ,
КРИСТАЛЛ СИТИ-102, №501 ТООТ

ЗУРГИЙН ШИФР 01/16

БОТЬ-6. ТАЙЛБАР БИЧИГ

**ДАРХАН-ЭРДЭНЭТИЙН ЗАМААС
АМАРБАЯСГАЛАНТ ХИЙД, САНТ
СУМ, ОРХОН СУМ ЧИГЛЭЛИЙН
АВТО ЗАМУУДЫН ТАЙЛБАР БИЧИГ**

Улаанбаатар хот 2016он



Захиалагч:
"Хөрөнгө оруулалтын газар"



Гүйцэтгэгч:
"АрСиЭсСи"ХХК

БОТЬ-6. ДАРХАН-ЭРДЭНЭТИЙН ЗАМААС
АМАРБАЯСГАЛАНТ ХИЙД, САНТ СУМ, ОРХОН СУМ
ЧИГЛЭЛИЙН ИНЖЕНЕРИЙН НАРИЙВЧИЛСАН
ЗУРАГ ТӨСӨЛ

ТАЙЛБАР БИЧИГ

ЗАХИРАЛ:  /Д. НЯМДАВАА/

ИНЖЕНЕР:  /Д. БАТБОЛД/



Улаанбаатар 2016 он

БҮЛЭГ-1. ЕРӨНХИЙ ЗҮЙЛ

i. ҮНДЭСЛЭЛ

Концессын тухай болон Монгол улсын холбогдох хууль, Засгийн Газрын 2013 оны 317-р тогтоолоор баталсан “Төрийн өмчийн концессын зүйлийн жагсаалт”-д нэмэлт, өөрчлөлт оруулсан. Энэхүү жагсаалтад орсон Амарбаясгалант хийд чиглэлийн 63 км хатуу хучилттай авто замыг засгийн газрын 2015 оны 8 дугаар төслийг хэрэгжүүлэх концессын төрөлд “зураг төсөл боловсруулах” гэж нэмэхээр шийдвэрлэсэн. Дээрх тоот тогтоолуудыг үндэслэн концессын гэрээ байгуулах эрхийг нэг талаас Хөрөнгө оруулалтын газар /цаашид “Эрх бүхий этгээд” гэх/ нөгөө талаас “СиЭфСи групп” ХХК-г /цаашид “концесс эзэмшигч” гэх/ нар нь “Амарбаясгалант хийд чиглэлийн хатуу хучилттай замыг барих, ажлын нарийвчилсан зураг төсөл зохиох ажлыг концессын зарчимаар уг чиглэлийн замыг 2016 нд эхэлж 2 жилийн хугацаанд барьж эхлэхээр гэрээ байгуулсан байна. Энэ ажлын бэлтгэл болгож “Амарбаясгалант хийд чиглэлийн чиглэлийн авто замын зураг төсөл боловсруулахаар концесс эзэмшигч “СиЭфСи” групп нь “АрСиСиЭс” ХХК-тай өдөр тоот гэрээ байгуулсан ба уг ажлыг 2016 оны 03 сарын 14ний өдрийн Зам, Тээврийн яамны төрийн нарийн бичгийн даргийн баталсан №05/16 тоот ажлын даалгаврын дагуу гүйцэтгэсэн болно.

ii. ТӨЛӨВЛӨЛТИЙН НОРМ

- Автозам төсөллөх БНБД 32-01-07
- Хот суурины гудамж зам төлөвлөх БНБД 32-01-04
- Авто замын гүүр ба хоолой төсөллөх БНБД 32-02-03
- Замын тэмдэг. Техникийн ерөнхий шаардлага MNS 4596:2014
- Замын тэмдэглэл. техникийн ерөнхий шаардлага MNS 4759:2014
- Автозамын уур амьсгал, геотехникийн нөхцөл АЗУАГН 2.01.01-2004

iii. АЖЛЫН БҮТЭЦ, БҮРЭЛДЭХҮҮН

- БОТЬ-1. ДАРХАН-ЭРДЭНЭТИЙН ЗАМААС АМАРБАЯСГАЛАНТ ХИЙД ЧИГЛЭЛИЙН 33.4КМ ХАТУУ ХУЧИЛТТАЙ АВТОЗАМ БОЛОН ТӨМӨРБЕТОН ГҮҮРИЙН НАРИЙВЧИЛСАН ЗУРАГ ТӨСЛИЙН ХАМТ
- БОТЬ-2. ДАРХАН-ЭРДЭНЭТИЙН ЗАМААС АМАРБАЯСГАЛАНТ ХИЙД ЧИГЛЭЛИЙН 33.4КМ ХАТУУ ХУЧИЛТТАЙ АВТОЗАМЫН ХӨНДЛӨН ОГТЛОЛЫН ЗУРАГ
- БОТЬ-3. ДАРХАН-ЭРДЭНЭТИЙН ЗАМААС САНТ СУМ ЧИГЛЭЛИЙН 17.2КМ ХАТУУ ХУЧИЛТТАЙ АВТОЗАМ БОЛОН ТӨМӨРБЕТОН ГҮҮРИЙН НАРИЙВЧИЛСАН ЗУРАГ ТӨСЛИЙН ХАМТ
- БОТЬ-4. ДАРХАН-ЭРДЭНЭТИЙН ЗАМААС ОРХОН СУМ ЧИГЛЭЛИЙН 5.0КМ ХАТУУ ХУЧИЛТТАЙ АВТОЗАМ БОЛОН ТӨМӨРБЕТОН ГҮҮРИЙН НАРИЙВЧИЛСАН ЗУРАГ ТӨСЛИЙН ХАМТ
- БОТЬ-5. ТЕХНИКИЙН ШААРДЛАГА
- БОТЬ-6. ТАЙЛБАР БИЧИГ
- БОТЬ-7. ИНЖЕНЕР ГЕОЛОГИЙН СУДАЛГААНЫ ДҮГНЭЛТ
- БОТЬ-8. БАЙРЗҮЙН ЗУРАГЛАЛЫН АЖЛЫН ТАЙЛАН
- БОТЬ-9. УСЗҮЙН СУДАЛГААНЫ ТАЙЛАН
- БОТЬ-10. ТӨСӨВ

iv. ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

Төслийн нэр: Дархан-Эрдэнэтийн замаас Амарбаясгалант хийд чиглэлийн инженерийн нарийвчилсан зураг төсөл боловсруулах

Байршил: Сэлэнгэ аймгийн Орхон сум, Сант сум, Баруунбүрэн сумын нутаг

Төслийг боловсруулахад оролцсон байгууллага, хүмүүс:

- “Ганхошуу” ХХК, (Инженер-геологийн судалгаа хийж тайлан гаргасан)
- “Замсервис” ХХК Геодези, (Байр зүйн судалгаа хийж тайлан гаргасан)
- МУ-ын зөвлөх инженер Ж.Баяраа, (Усзүйн судалгаа хийж тайлан гаргасан)
- “САТУ” байгаль орчны төлөв байдлын судалгаа

v. ТӨСЛИЙН ТЕХНИКИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД:

№	Үзүүлэлтүүд	Хэмжих нэгж	1-р хэсэг Дархан- Эрдэнэтийн замаас Амарбаясгалант хийд чиглэлийн автозам	2-р хэсэг Дархан- Эрдэнэтийн замаас Сант чиглэлийн автозам	3-р хэсэг Дархан- Эрдэнэтийн замаас Орхон сум чиглэлийн автозам
1	Замын зэрэг	-	III	IV	
2	Замын урт	км	33,4	17,2	5,0
3	Тойруугийн тоо	ш	34	22	5
4	Тойруугийн хамгийн бага радиус	м	120	80	500
5	Тойруугийн хамгийн их радиус	м	6000	5000	2500
6	Тойруугийн нийт урт	м	14730	7680,8	2226,6
7	Тойруугийн трассад эзлэх хувь	%	44	45	44
8	Босоо гүдгэр муруйн хамгийн бага радиус	м	1000	4000	6000
9	Босоо гүдгэр муруйн хамгийн их радиус	м	38950	420000	20000
10	Босоо хотгор муруйн хамгийн бага радиус	м	1650	3200	6000
11	Босоо хотгор муруйн хамгийн их радиус	м	40850	133000	20000
12	Дагуугийн хамгийн их налуу	%	9,7	6,0	2,3
13	Дагуугийн хамгийн их налууугийн үргэлжлэх урт	м	70	110	188
14	Замын далангийн өргөн	м	11,0	9,0	
15	Зорчих хэсгийн өргөн	м	7	6	
16	Хөвөөний өргөн	м	2,0x2	1,5x2	1,5x2
17	Үүнээс бэхэлгээтэй хэсэг нь	м	1,5м	1,0м	байхгүй
18	Өндөрлөсөн далангийн хажуу налуу	m:n	1:2,0		
19	Ухмалын хажуу налуу	m:n	1:1.5: 1:2.0		
20	Хучлагын төрөл	-	Асфальтобетон		


БҮЛЭГ-2. ЗАМ ТАВИГДАХ ГАЗАР ОРНЫ ТУХАЙ

Төслийн зам нь Сэлэнгэ аймгийн Баруунбүрэн, Сант, Орхон сумын нутагт тавигдах ба дараах хэсгүүдэд хуваагдана. Үүнд:

- a) 1-Р ХЭСЭГ. Дархан-Эрдэнэтийн замаас Амарбаясгалант хийд чиглэлийн автозам
- b) 2-Р ХЭСЭГ. Дархан-Эрдэнэтийн замаас Сант чиглэлийн автозам
- c) 3-Р ХЭСЭГ. Дархан-Эрдэнэтийн замаас Орхон сум чиглэлийн автозам

2.1 ЗАМЫН ЗУРВАСЫН БАЙРШИЛ:

Дархан-Эрдэнэтийн замаас Орхон, Сант сум, Амарбаясгалант хийд чиглэлд 55.6 км хатуу хучилттай авто замын эхний хэсэг нь Дархан-Эрдэнэтийн замын Орхоны гүүрийн урд талаас эхэлж хойш 5 км үргэлжлэн Орхон сумын төвд төгсөнө. Дараагийн хэсэг нь Орхоны гүүр өнгөрч Дархан-Эрдэнэтийн замаас эхэлж зүүн хойш 17.2 км үргэлжлэн Сант сумын төвд төгсөнө. Гурав дахь хэсэг нь Дархан-Эрдэнэтийн замаас эхэлж хойш 33.4 км үргэлжлэн Амарбаясгалант хийд хүрч төгсөнө.




Зураг 2-1. Авто замын байршлын тойм зураг

Газрын гадаргын хотгор гүдгэр

Судалгааны районы ихэнхи хагаст тархсан өндөр уулс, толгодууд нь харьцах өндрөөрөө хэдэн арван метр байхаас гадна хажуу нь маш налуу, орой нь шовх хэлбэртэй байх ба оройдоо мөнх цасгүй юм. Төв Азийн геоморфологийн тойрогийн Орхон-Сэлэнгийн их мужийн Сэлэнгийн мужид энэхүү замын зурвас хамаарна. Хотгор гүтгэрийн үндсэн 3 хэв шинж энд тааралдана. Үүнд:

- Нам өндөрлөг уулс
- Уулс хоорондын хоолой, хөндий
- Голуудын хөндий

Нам өндөрлөг уулс нь 1296.0-1007.0 м өргөгдсөн ухаа гүвээ, толгод болно. Замын эхний хэсэгт тааралдах Цагаан хөтөл уулс, Дамбын Хүүш уулсын салбарууд боржинлог чулуулгаас, замын шугамын дунд үеэс тааралдах Агуйт, Банзрагч, Голын Бүдүүн уулс нь тунамал чулуулгаас зонхилон тогтсон. Уулсыг бүрдүүлэгч чулуулгийн өгөршилд эрчимтэй өртсөн учраас уулсын хажуу бэл, хормой нь үхэр чулуу болон хэмхдэс материалаар хучигдсан.



Зураг 2-2. Авто замын зурвас орчмын уул зүйн тойм зураг

Уул зүйн нөхцөл

Судалгааны районы ихэнхи хагаст тархсан өндөр уулс, толгодууд нь харьцах өндрөөрөө хэдэн арван метр байхаас гадна хажуу нь маш налуу, орой нь шовх хэлбэртэй юм. Тэдгээрийн хооронд жижиг хотос буюу тэгш гадарга өргөн хөндийнүүд оршино. Тэнд заримдаа жижиг нуур юмуу тойром, хужир марц үүссэн байна. Зарим газарт гол горхигүй хуурай хөндий орших ба хөндийнүүд нь өргөн, налуу хажуутай, тэгшивтэр ёроолтой юм.

Дархан-Эрдэнэтийн авто замаас Амарбаясгалант хийд чиглэлийн авто зам

Нам өндөрлөг уулс нь 1296.0-1007.0 м өргөгдсөн ухаа гүвээ, толгод болно. Замын эхний хэсэгт тааралдах Цагаан хөтөл уулс, Дамбын Хүүш уулсын салбарууд боржинлог чулуулгаас, замын шугамын дунд үеэс тааралдах Агуйт, Банзрагч, Голын Бүдүүн уулс нь тунамал чулуулгаас зонхилон тогтсон. Уулсыг бүрдүүлэгч чулуулгийн өгөршилд эрчимтэй өртсөн учраас уулсын хажуу бэл, хормой нь үхэр чулуу болон хэмхдэс материалаар хучигдсан. Уулс хоорондын хөндий, хоолой нь делюви-пролювийн хурдсаар дүүргэгдсэн, гадарга нь бага зэрэг налуувтар, хэрчигдэл бараг байхгүй.

Дархан-Эрдэнэтийн засмал замаас Сант сум чиглэлийн авто зам

Төв Азийн геоморфологийн тойрогийн Орхон-Сэлэнгийн их мужийн Сэлэнгийн мужид энэхүү замын зурвас хамаарна. Хотгор гүтгэрийн хэв шинжийн хувьд элэгдлийн нам өндөрлөг уулс болох Дааган дэл (1004.0 м), Шандын гозгор уул (970.6 м), сумын төвийн хойгуур орших толгод (756-800 м), хуримтлалын хэв шинжит Еэвэн, Орхон голын татам, дэнж, идэгдлийн хэв шинж болох голуудын хөндий болон түр зуурын урсгал усны сайрууд тааралдана. Элэгдлийн нам өндөрлөг уулсын хажуу нь огцом эгц биш, өгөршлийн бүтээгдэхүүнээр хучигдсан (элювий делювий хурдас). Авто замын шугам Дааган дэлийн хормойноос хойшоо Шандын гозгор уул хүртэл Орхон голын II дэнжийн гадаргаар өнгөрнө. Шандны гозгорын урд энгэрээс эхтэй томоохон амны гүнзгий жалгын адгаар нь дайран өнгөрнө. Энэхүү жалга нь 10 м гаруй өндөртэй. Геологийн насны хувьд чулуун зэвсгийн үеэс хойш үүссэн.

Дархан-Эрдэнэтийн авто замаас Орхон сум чиглэлийн авто зам

Төв Азийн геоморфологийн тойрогийн Орхон-Сэлэнгийн их мужийн Сэлэнгийн мужид энэхүү замын зурвас хамаарах бөгөөд Орхон голын өндөр дэнж болох хуримтлалын төрлийн хотгор гүдгэр зонхилсон. Сумын төв нь бэсрэг уулсын хэв шинж бүхий хотгор гүдгэр бүхий талбайд оршино. Орхон голын өндөр дэнжийн гадарга хэрчигдэл байхгүй. Дархан-Эрдэнэтийн засмал замаас Орхон сумын төв уруу салах замын эх орчимд баруун гар талаас шороон авто замын дагуу үүссэн 1.3 м өргөнтэй, 0.42 м гүнтэй жалга бөгөөд тэр нь замын шугам уруу ойртохдоо задгайрч нэл урсгал үүсгэнэ. Орхон сумын төвөөс урагш 2 км-т Орхон голын 1-р дэнжид орших жижиг нуурын харалдаа салаалсан жалга замын шугамын баруун гар талаас орж ирнэ. Энэ хэсэгт уулнаас нэл урсгал ширүүн аадар борооны үед үүсэх магадлалтай. Сумын төвийн урдуур 160 м гаруй өргөнтэй алсын эхтэй сайр өнгөрнө. Энэ сайрыг өнгөрөнгүүт замын шугамын дагуу 1.0 м хүртэл өргөнтэй 0.4 м хүртэл гүнзгий жалга шинээр үүсэж байгаа нь ажиглагдсан.

Хөрс ургамлын нөхцөл

Судалгааны талбай нь хөрсний мужлалаар Хангайн их мужийн Сэлэнгийн хөндийн дэд мужид хамаарагдаж хөрсөн бүрхэвчинд ойт хээрийн хүрэн, цайвар хүрэн хөрс зонхилж тэгш тал, ухаа гүвээ болон төвгөр газраар голчлон тархана. Еэвэн голын хөндийгөөр болон зарим нэг хотгорт нуга-намгийн буюу намгийн хөрс бага талбайг эзлэж оршино. Хөрсний ширхэгийн бүрэлдэхүүн нийт талбайд хайрга агуулсан элс, элсэнцэр, хөнгөн шавранцар байна.

Судалгааны район нь ургамал зүйн хувьд ЕвроАзийн ойт хээрийн их мужийн ойт хээрийн бүсэд хамаарагдаж ойт хээрийн ургамал дагнана.

Ялангуяа хялгана-хазаар өвс хиаг-хялганат, хялгана-хазаар, монгол өвс-агьт хээр голлохын хамт хиаг-хялганат хээр нэн түгээмэл байхын сацуу Эгийн голын хавьд нарсан өвст, хялгана-нарсан өвст хээр, хялгана-агьт хээр байна. Хотгор хонхор газраар хялгана-ширэгт хээрийн зэрэгцээгээр дэрс нилээн ургана.



Зураг 2-3. Ургамал хөрсний байдал

Ус зүйн нөхцөл

Судалгааны талбай нь Хойт Мөсөн далайн голуудын ай савд Сэлэнгэ мөрний үндсэн цутгал Орхон голын ус хураах талбайд оршино.

Замын зурвас нь байнгын урсгалт Еэвэн түүний цутгал жижиг голуудыг болон хаврын шар усны болон зуны хур борооны үерийн үед урсацтай болдог хуурай сайр, жалгыг хөндлөн гарна. Эдгээр нь ус зүйн хувьд урьд өмнө судлагдаж байгаагүй болно.

2.2 УУР АМЬСГАЛ

Судалгааны район нь Монгол орны бусад нутгийн нэгэн адил эх газрын эрс тэс уур амьсгалтай бөгөөд ерөнхийдөө өвөл нь удаан (хүйтэвтэр, байнга цас их унадаг, эрс хүйтрэх, хүчтэй салхилах), зун нь богино (аагим халуун, их бороо орох, зарим жил ган болох), хавар, намар уулсын хөндий дагасан салхи их тохиолдох чийглэг хахир хүйтэн байх уур амьсгалын бичил мужид оршино.

Уур амьсгалын үндсэн үзүүлэлтийг Булган аймгийн Хангал харуулын болон Эрдэнэт станцын олон жилийн ажиглалтын материалыг болон “Барилгад хэрэглэх уур амьсгалын ба геофизикийн үзүүлэлтүүд” /БНБД 2.01.01-93/, “Барилгад хэрэглэх уур амьсгалын ба геофизикийн үзүүлэлтүүд” (Авто замын уур амьсгал, геотехникийн нөхцөл) /БНБД 2.01.01-2004/-ийг ашиглан агаарын температур, хөрсний температур, агаарын чийгшил, салхины горим гэсэн үзүүлэлтээр өгч хүснэгтээр харуулав.

Агаарын температур

Судалгааны бүс нутагт олон жилийн агаарын температур +1.40С -1.60С байгаа нь сэрүүн бүсэд багтахыг харуулна. Агаарын температур хавар 3-р сарын сүүлчийн арав хоногт 00С-ийг давж дулаарч, хамгийн дулаан 7-р сард +15,4-оос +20,10С дундажтай байх ба үнэмлэхүй их нь +33,20С байна. Намар 10-р сарын дунд арав хоногт 00С-ийг давж хүйтэрч, хамгийн хүйтэн 1-р сард -19.80С-ээс -23.50С дундажтай байх ба үнэмлэхүй бага нь -42.60С байна.

Агаарт цочир хүйтрэлт жил болгон ажиглагдахгүй боловч олон жилийн дундажаар цочир хүйтрэлт ажиглагдах анхны хугацаа нь намар 9-р сарын дунд арав хоногт, эцсийн хугацаа нь хавар 5-р сарын эхээр ажиглагдаж цочир хүйтрэлгүй үеийн үргэлжлэх хугацаа 93-120 орчим хоног байна.

Хөрсний температур

Бүс нутгаар хөрсний гадаргын температурын олон жилийн дундаж температур +3.80С байх ба агаарын температурын жилийн явцтай нэгэн адил 1-р сард хамгийн хүйтэн (үнэмлэхүй бага температур -47.60С), 7 дугаар сард хамгийн дулаан (үнэмлэхүй их температур +64.50С) байна.

Хөрсний гүнд улирлын хөлдөлтөөр 3.2м хүрч хөлдөх ба хөрсний гүнд ховор алаг цоог тархацтай цэвдэгтэй бүсэд оршино.

Чийгшил ба тунадас

Судалгааны районд газар зүйн байрлал болон хур тунадасны хэмжээ зэргээс хамаарч хагас чийглэг, чийглэгдүү уур амьсгалтай бүсэд багтана. Жилийн дулаан улирлын дундаж харьцангуй чийгшил 50-70% байна. Хүйтний улиралд агаарын харьцангуй чийгшил 80-85%, харин дулааны улиралд 60-70% байх ба жилийн явц нь өвөл, зун их утгаа авч хавар, намар хамгийн багасч 40-55% болдог байна.

Уг бүс нутгийн хур тунадасны горим нь агаар мандлын орчил урсгал, орон нутгийн хотгор, гүдгэрийн байдал, цаг улирал, дэвсгэр гадаргаас уурших ууршил зэргээс хамаарна. Олон жилийн дундаж байдлаар 77.0-325.0мм тунадас унах ба нийт хур тунадасны 80-90 орчим хувь нь зөвхөн дулааны улиралд буюу 5-9 дүгээр саруудад ордог байна.

Анхны цас өндөр ууландаа эрт буюу 8-р сарын сүүлчээр, эцсийн цас 6-р сарын эхний 10 хоногт ордог байна. Өвөл 5-10 см зузаан цасан бүрхүүл 110-150 хоног тогтож 4-р сарын дунд арав хоногт сүүлчийн цас ажиглагдах ба 3 дугаар сарын дундаас хайлж эхэлдэг. Манай орны газар нутгийн хотгор, гүдгэрийн ялгаанаас шалтгаалж цасны зузаан нь нутаг бүхэнд харилцан адилгүй байна. Цасан бүрхүүлийн зузааны горимыг цасны 10 хоногийн дундаж зузаан, цасны хамгийн их зузааны дундаж зэрэг үзүүлэлтээр илэрхийлдэг. Цасны хээрийн хэмжилтээр гаргасан 10 хоногийн дунджаас үзвэл уулархаг хэсэгт (уулсын хоорондох хөндий) 15 см ба түүнээс дээш, хээрийн бүсэд 5 см хүртэл, говьд 1-2 см-ээс төдийлөн хэтэрдэггүй байна. Цасан бүрхүүлийн дундаж хамгийн их зузаан өндөр уулын бүсэд 30 см-ээс их, ойт хээрийн бүсэд 15-20 см, хээрт 10-15 см, говьд цасан бүрхүүл тогтсон үедээ 2-5 см (10 см-ээс бага) хүрдэг байна. Цасны зузааны хэмжилтийн олон жилийн мэдээгээр тухайн бүс нутагт тодорхой (5, 30, 50, 80 ба 95%) хангамжтай байх цасны зузааныг цаг уурч, эрдэмтэн Б.Жамбаажамцын судалснаар Монгол орны нутаг бүрт харилцан адилгүй байдаг байна. Цасны нягт 0.17г/см³ байдаг

Сэлэнгэ, Булган аймагт хийсэн судалгааг дараахь хүснэгтэд харуулав.


Станцын нэр	Хамгийн их зузаан, см	Хангамж, %					Хамгийн бага зузаан, см	ОЖД зузаан, см
		5	30	50	80	95		
Баруунбүрэн	66	60	34	29	23	11	3	11
Сант	42	34	15	12	7	4	4	7
Орхон	45	35	21	15	10	4	3	9

Дээрх хүснэгтээс харахад Хангайн нурууны салбарт байрлах станцуудад 5%-ийн хангамжтай байх цасан бүрхүүлийн зузаан 40-60см байдаг байна. Хэдийгээр уг судалгааг аймгийн бусад станц, харуулын хэмжээнд хийгээгүй боловч энэхүү судалгааны дүнд үндэслэн бусад нутаг дахь 5%-ийн хангамжтай цасан бүрхүүлийн зузааныг үнэлж болох юм. Тухайлбал Хангайн нурууны өндөрлөг хэсэг болон Сэлэнгэ мөрөн Эгийн голын сав нутгаар 5%-ийн хангамжтай цасан бүрхүүлийн зузааныг 60 см гэж үнэлж болно.

Салхи

Тус районд баруун ба баруун хойт зүгийн салхи зонхилох ба харин хүйтний улиралд зүүн ба зүүн өмнөд зүгийн салхи зонхилно. Салхины хурд олон жилийн дунджаар 1.6-3.8 м/с байх ба 100 жилд тохиолдож болох салхины хурд 30.0 м/с байна. Салхины чиглэл бүрийн давтагдлын диаграммыг үзүүлэв.

Орхон станц



Салхигүй үеийн давтагдал СО 54.4

Салхигүй үеийн давтагдал СО 36.2




Салхигүй үеийн давтагдал СО 61.4

Салхигүй үеийн давтагдал СО 45.2

2.3 АВТО ЗАМЫН УУР АМЬСГАЛЫН НӨХЦӨЛ

Авто замын гүүр барихаар төлөвлөж буй газар нутаг нь Монгол орны авто замын уур амьсгал-геотехникийн нөхцлийн IIА буюу Хангай-Хэнтийн уул тайга ба Сэлэнгэ-Орхоны савын ойт хээрийн чийглэгдүү, нэн хүйтэн, хахир дэд бүсэд хамаарч байна.

Энэ бүсийн онцлог нь Авто замын уур амьсгалын мужлалаар Хангайн өндөр уулын нэн хүйтэн-чийглэгдүү байх уулт хээрийн хахир газрууд багтдаг. Мөн уур амьсгалын хүчтэй салхи шороон шуургатай, халуун бүгчим, хуурай онцлогтой. Олон жилийн цэвдэг чулуулаг алаг цоог тархсан, авто замын уур амьсгалын улирлын хөлдөлт-гэсэлттэй. Уулархаг хээртээ цасархаг, цас борооноос намаг шавар ихтэй, бороорхог, аянгалаг, хээр талдаа цас нимгэн нягтархаг, хөндий дагасан салхитай, хахир хүйтэн жаварлаг байх дэд бүсэд хамаарч байна.



Энэ бүсийн зарим онцлог үзүүлэлтүүдийг доорхи хүснэгтүүдээр үзүүлэв.

Бүсийн үндсэн тодорхойлолт.

Бүсийн дугаар, нэр	дэд бүсийн индекс	Бүсийн товч тодорхойлолт	Авто замын гео уур амьсгал, гео физикийн онцлог
II авто замын уур амьсгалын уулт хээрийн бүс	IIA уулын ба талын ойт хээрийн дэд бүс	Хангай-Хэнтийн уул тайга ба Сэлэнгэ-Орхоны савын ойт хээрийн чийглэгдүү сэрүүн, нэн хүйтэн, хахир дэд бүс	-Олон жилийн цэвдэг чулуулаг алаг цоог тархсан, авто замын уур амьсгалын улирлын хөлдөлт- гэсэлттэй, хүйтний овойлт болон суумтгай лёсс маягийн хурдас тархсан. Уулархаг хээртээ цасархаг, цас борооноос намаг шавар ихтэй, бороорхог, аянгалаг, хээр талдаа цас нимгэн нягтархаг, салхитай, хахир хүйтэн жаварлаг.

Авто замын уур амьсгалын улирлын хугацаа*

Бүс	Дэд бүс	өвөл			хавар		зун		намар
		эхлэх	дуусах	хоног	Дуусах	хоног	дуусах	хоног	хоног
II	IIA.	1-9.XI 5.XI	15-24.III 19.III	126-143 134	6-12.Y 9.Y	45-52 48	8-19.IX 13.IX	112- 156 129	44-54 49

Тайлбар: * өвлийн дуусах хугацаа, хаврын эхлэл, хаврынх, зуны эхлэл, зуных, намрын эхлэл, өвлийн эхлэх, намрын дуусах хугацаа болно.

Хөрсний хөлдөлт гэсэлтийн уур амьсгалын хугацаа

Бүс	Дэд бүс	Хөрсний хөлдөлт гэсэлтийн норматив гүн,м*	хөлдөлт			гэсэлт		
			эхлэх	Дуусах	хоног	эхлэх	дуусах	хоног
II	IIA.	2.5,3.0,3.2, 3.5	20-30.X 25.X	15.II-30.IY 5.IY	120- 195 160	15.III- 10.IY 25.III	15.IY31.Y 23.IY	20- 50 35

*Тайлбар: 1 дэх тоо нь шавар, шавранцар, 2 дахь тоо нь элсэнцэр тоосорхог, 3 дахь тоо нь том болон дунд зэрэг элс, хайргархаг, 4 дэх тоо нь том хэмхдэст хөрсний цэвдэгтэй нутагт ул хөрсний гэсэлтийн цэвдэггүй нутагт ул хөрсний улирлын хөлдөлтийн норматив гүн, м-ээр болно.

Хөрс, агаарын температурын (°C) үзүүлэлт.

Бүс	Дэд бүс	Хөрсний гадаргын температур, °C				Агаар орчны дундаж температур, °C		
		олон жилийн дундаж	Хамгийн халуун	Хамгийн хүйтэн	0° нэвчих гүн,см*	Олон жилийн дундаж	Хамгийн хүйтэн сарын	Хамгийн дулаан сарын
II	IIA.	-0...-3	55-60	-45...-55	300-400	-3...-8	-23...-33	15...17

Тайлбар*-0°C нэвчих гүн ул хөрсний төрлөөс хамаарах тул дээд доод хязгаарыг авав.

Автозамын барилгын үйлдвэрлэлийн ажлын дулаан хүйтэн үе

Бүс	Дэд бүс	Дулааны улирал*			Хүйтний улирал
		эхлэх	дуусах	хоног	хоног
II	IIA.	20.IY	05.X	168	197

Тайлбар: * - Автозамын үйлдвэрлэлийн хүйтэн улирлын эх нь дулаан улирлын төгсгөл, хүйтэн улирлын төгсгөл нь дулаан улирлын эх болдог.

Авто замын уур амьсгалын жилийн 4 улирлын салхины хурд, агаарын даралт, харьцангуй чийгшил

Дэд бүс	Салхины хурд, м/с				Даралт, мм Hg баганын өндрөөр	Харьцангуй чийгшил, %
	Өвөл	Хавар	Зун	Намар		
IIA.	0.7-2.5	2-4	1-2	1-2	550-650	60-70

Авто замын үйлдвэрлэл, замчдын хөдөлмөрт уур амьсгалын нөлөөллийг үнэлэх итгэлцүүрүүд

Дэд бүс	Нөлөө үйлчлэлийн итгэлцүүр				
	Хүйтний	Хахирын	Халууны	Хур тунадасны	Чийгшлийн
IIA	1.14	0.84	0.88	1.28	1.10

Авто замын уур амьсгалын бүсүүдэд халуун асфальт бетон хольц бэлтгэж дэвсэхэд тохиромжтой хугацаа

Дэд бүс	Асфальт болон замын хучилт		
	Эхлэх	Дуусгах	Хоног
IIA	23.IY-17.Y (2.V)	16.IX-28.IX (6.IX)	93-153 (127)

Авто замын уур амьсгалын бүсүүдэд хүйтэн, бүлээн асфальт бетон хучилт хийхэд тохиромжтой хугацаа

Дэд бүс	Асфальт болон замын хучилт		
	Эхлэх	Дуусгах	Хоног
IIA	5. III-1.I V (19.III)	24.X-22.XI (7.XI)	206-262 (234)

Хээр гадаа ажиллах авто замын ажилчдын хөдөлмөрийн био уур амьсгалын нөхцөл

Дэд бүс	Хүчилтөрөгч-чийн нягт, г/см ³	Хувцас хунарын дулаан чанар, КЛО (хүндэвтэр ажлыг нөхцлөөр тооцов)			Уур амьсгал хүний биед, хоног		
		өвлийн	Хавар, намрын	Зуны	Таатай	Цочроох	Хурц
IIA.	250-270	4.5-4.5	3.0-3.5	1.5-1.8	170-180	105-110	80-85

Гол мөрний гадаргын усны горимын зарим үзүүлэлт

Бүс	Дэд бүс	үзүүлэлт							
		Нягтшил /км/км ² /	Жилийн дундаж урсац л/сек	Урсацын давхраа мм	Шар усны үерийн урсац мм	Урсацын модуль л/сек км ²	Мөсний хамгийн их зузааны дундаж см	Мөсний үзэгдэл эхлэх хугацаа	Мөс ханзрах хугацаа
II	IIA.	0.2-0.3	2-4	50-100	50-100	0.8-1.5	100-125	10-20.XI	1-21. Y

БҮЛЭГ-3. ГЕОДЕЗИЙН ХЭМЖИЛТИЙН АЖИЛ

3.1 ЕРӨНХИЙ ЗҮЙЛ

Дархан-Эрдэнэтийн замаас Амарбаясгалант хийд болон Сант сум хүртэлх хэсгийн автозамын дэвсгэр зургийн геодезийн хэмжилт, зураглалын ажлыг “Замсервис” ХХК-ийн геодезийн баг 2016 оны 03-р сарын 18-аас 04-р сарын 01-ны хооронд хийсэн бол Дархан-Эрдэнэтийн замаас Орхон сум хүртэлх хэсгийг “Геотэс”ХХК-ийн геодезийн баг 2015 оны 06-р сарын 03-аас 06-р сарын 08-ны хооронд хийсэн. Захиалагчаас ирүүлсэн Техникийн даалгавар болон холбогдох заавар, журам, стандартыг баримтлан дараах ажлуудыг гүйцэтгэсэн байна. Үүнд:

- Автозамын трассын дагууд зураглалын тулгуур сүлжээ байгуулсан.
 - Хуучин цэгийн судалгаа /5 цэг/
 - Шинэ цэг суулгалт /31 цэг/
 - GPS-ийн сүлжээний хэмжилт, боловсруулалт /21 цэг/
 - Нивелирдлэг /110,4 км/
 - Байрзүйн тоон зураглал /551га/
 - Өнцгийн оройн гадаслагаа, хэмжилт /580цэг/

Дархан-Эрдэнэтийн замаас Амарбаясгалант хийд болон Сант сум хүртэлх хэсгийн автозамын трассын геодезийн хэмжилт, зураглалын ажилд байрлалын хувьд олон улсын WGS-84 солбицлын тогтолцоог, өндрийн хувьд Балтын тэнгисийн өндрийн тогтолцоог авч хэрэглэсэн ба том масштабын зургийг дэлхийн хөндлөн меркаторын UTM /Universal Transverse Mercator/ тусгагаар хавтгайд шилжүүлсэн байна. Дархан-Эрдэнэтийн замаас Орхон сум хүртэлх хэсгийг зураглалын ажлыг “Геотэс”ХХК нь ITRF-97 системд /ТМ тусгаг/ 48-р бүсэд хийсэн байна.

3.2 ГЕОДЕЗИЙН ЦЭГ СУУЛГАЛТЫН АЖИЛ (РЕПЕР ЦЭГ)

Автозамын трассын дагууд “Геодезийн цэг тэмдэгт байгуулах ажлын заавар”-ыг мөрдлөг болгон нийт 29 цэг /ГТЦ/-ийг шинээр суулгасан. Эдгээр цэгүүдийн байрлалыг сонгохдоо автозамын трассын дагууд 1.5-2.0 км тутамд өөр хоорондоо харагдалттай, тэнхлэгээс 50-60 метр зайд газар шорооны ажилд өртөхгүй байхаар тооцсон болно. Мөн шаардлагатай газруудад завсрын түр цэгийг төмөр гадсаар бэхэлсэн.

Захиалагчаас гар GPS-ийн өгсөн координатын дагуу өнцгийн оройнуудыг олж нарийн координатыг RTK хэмжилтээр хэмжсэн. Мөн трассын эхлэл, төгсгөл, өнцгийн оройн цэгүүдийг 20см-ийн урттай төмөр гадсаар тэмдэглэж цэгийн дугаар тайлбар бичсэн пайз зүүж бэхэлж өгсөн.

Трассын дагуух 100м тутамын тэнхлэгийн гадаслагааг захиалагчаас өгсөн координатын дагуу газар дээр гадаслагаа хийж пикет бичсэн пайз хадсан болно.

Шинээр суулгасан цэгүүдийн солбицол, өндрийн жагсаалт III -р хэсэг. Дархан-Эрдэнэтийн замаас Орхон сум чиглэлийн автозам

Хүснэгт 3-1

№	Цэгийн нэр	WGS-84		UTM-49N		H (m)
		B (° ' '')	L (° ' '')	N (m)	E (m)	
1	PP-902	49 06 29.04	105 23 27.91	5441719.583	528554.490	731,79
2	PP-903	49 07 19.469	105 23 30.19	5443277.454	528592.811	732,05

II-р хэсэг. Дархан-Эрдэнэтийн замаас Сант сум чиглэлийн автозам

№	Цэгийн нэр	WGS-84		UTM-49N		H (m)
		B (° ' ")	L (° ' ")	N (m)	E (m)	
1	Rp001	49 14 30.99	105 21 43.01	5454414,946	526345.263	731,770
2	Rp002	49 13 25.73	105 21 03.18	5452395,979	525549,202	729,106
3	Rp003	49 12 43.04	105 22 09.24	5451083,987	526891,852	719,360
4	Rp004	49 11 59.71	105 22 50.70	5449750,175	527737,272	713,099
5	Rp005	49 11 08.57	105 21 36.55	5448163,388	526244.314	738,110
6	Rp006	49 10 35.18	105 21 34.02	5447132,248	526198,001	731,639
7	Rp007	49 09 45.13	105 21 07.12	5445584.085	525660.618	744,672
8	Rp008	49 08 58.02	105 20 16.00	5444124,598	524631,86	792,887
9	Rp009	49 08 25.33	105 20 02.08	5443113,795	524354,398	794,076

I-р хэсэг. Дархан-Эрдэнэтийн замаас Амарбаясгалант хийд чиглэлийн автозам

№	Цэгийн нэр	WGS-84		UTM-49N		H (m)
		B (° ' ")	L (° ' ")	N (m)	E (m)	
10	Rp010	49 14 11.83	104 58 55.51	5453760,361	498695,921	1004,869
11	Rp011	49 15 05.70	104 58 37.99	5455423.879	498342.103	1032,199
12	Rp012	49 16 12.89	104 58 10.50	5457499,014	497787.337	1057,397
13	Rp013	49 17 04.55	104 57 46.41	5459094.601	497301.297	1123,787
14	Rp014	49 17 37.45	104 58 38.98	5460110.178	498363,605	1179,148
15	Rp015	49 18 13.11	104 59 57.91	5461211.178	499957.871	1101,655
16	Rp016	49 19 10.81	105 00 53.19	5462992.931	501073.815	1036,807
17	Rp017	49 20 07.92	105 02 04.61	5464757,047	502514,644	996,923
18	Rp018	49 21 24.89	105 02 34.03	5467134.252	503106,974	1051,212
19	Rp019	49 21 53.69	105 03 28.59	5468024,384	504206,941	995,097
20	Rp020	49 23 08.81	105 03 44.14	5470344,598	504518,598	1105,046
21	Rp021	49 24 14.16	105 04 18.72	5472363.136	505213.848	1010,522
22	Rp022	49 25 17.12	105 04 35.62	5474307.825	505552,456	959,356

23	Rp023	49 26 24.82	105 05 03.00	5476399.138	506101,765	967,103
24	Rp024	49 27 13.74	105 04 48.53	5477909.624	505808.808	996,153
25	Rp025	49 28 23.82	105 05 07.93	5480074,026	506196,858	1010,794
26	Rp026	49 12 48.98	104 59 09.08	5451201.981	498969.954	931,183

3.3 **ӨНДРИЙН СҮЛЖЭЭНИЙ ХЭМЖИЛТ, БОЛОВСРУУЛАЛТЫН АЖИЛ**

Автозамын трассын дагуух өндрийн сүлжээг "I, II, III, IV ангийн нивелирдлэгийн ажил гүйцэтгэх үндсэн заавар"-ыг мөрдлөг болгон Балтын тэнгисийн өндрийн тогтолцоонд, нивелирдлэгийн III ангийн программаар шууд, урвуу чиглэлд гүйцэтгэсэн. Дараах цэгүүдийг ашигласан. үүнд I-р хэсгийн замын трассын төгсгөлөөс 300м-т орших геодезийн цэг ГЦТ-7135 ашигласан. II-р хэсгийн замын трассын 15км-т орших геодезийн цэг ГТЦ-6350 GPS-н сүлжээний цэг цэгүүдэд холбон өндрийг баталгаажуулан шалгасан цэгүүдийг ашиглан битүү сэлгэц болгон тэгшитгэн бодсон.

Нивелирдлэгийн ажилд В-20 тоон нивелирийн иж бүрдлийг ашигласан ба тус нивелирийн техникийн үзүүлэлт нь:

- Дурангийн оптик өсгөлт 32^x
- 1 км нүүлтийн алдаа оптик хэмжилтээр 0,7 мм
- Автомат компенсаторын нарийвчлал 0,3"
- Автомат компенсаторын ажиллах хязгаар ± 15'
- Хамгийн бага хэмжих зай 0,2 м

3.4 **АВТОЗАМЫН ТРАССЫН ЗУРАГЛАЛЫН ХЭМЖИЛТ, БОЛОВСРУУЛАЛТЫН АЖИЛ**

Автозамын трассын зураглалыг "1:5000, 1:2000, 1:1000, 1:500-ны масштабтай байр зүйн зураглалын ажлын заавар"-ыг мөрдлөг болгон шинээр суулгасан GPS-ийн сүлжээний цэгүүдэд үндэслэн трассын тэнхлэгийн дагууд GPS-ийн технологиор, зураглалын RTK горимд, WGS-84 солбицлын системд үйлдсэн. Хээрийн хэмжилтийн ажилд GPS-ийн 2 долгионы GRX1 суурин хүлээн авагчийн иж бүрдлийг, суурин боловсруулалтын ажилд Autocad, Sokkialink, SDR mapping and design зэрэг программ хангамжуудыг тус тус ашигласан. 1:1000, 1:500-ны масштабтай байр зүйн зурагт газрын гадаргын үндсэн элементүүд болон бусад биет юмсыг "1:5000, 1:2000, 1:1000, 1:500-ны масштабтай байр зүйн зургийн томъёолсон тэмдэг" зааврын дагуу дүрсэлсэн ба хэвлэлийн эхийг захиалагчийн хүсэлтээр 1:5000-ны масштабтаар А-1 форматаар бэлтгэсэн. Цэг тэмдэгтийн хувийн хэрэг болон дэлгэрэнгүй тайланг "Зам сервис"ХХК болон "Геотэс"ХХК тайлангаас үзнэ үү.

БҮЛЭГ-4. ИНЖЕНЕР ГЕОЛОГИЙН СУДАЛГАА

4.1 СУДАЛГАА ЯВУУЛСАН ҮНДЭСЛЭЛ БА ТАЙЛАНГИЙН БҮТЭЦ

Их засварын ажил хийгдэх авто зам дагуух талбайн инженер геологийн судалгааны ажлыг “Ганхошуу” ХХК хийж гүйцэтгэн тайланг бичиж боловсруулав. Судалгааны ажлын тайлан нь Тайлангийн бичмэл текст болон туршилт, шинжилгээ, зүсэлтүүд багтсан. Авто замын трассын инженер-геологийн хээрийн судалгааны ажлыг “Ганхошуу” ХХК-ийн инженер Л.Ганзоригийн удирдлагаар өрмийн мастер-жолооч Ё.Ганбаатар, инженер Ц.Сүхбаатар, өрмийн туслах Б.Нямсүрэн, Б.Батхишиг нарын бүрэлдэхүүнтэй бригад гүйцэтгэв.

4.2 СУДАЛГААНЫ АРГА, АРГАЧЛАЛ.

Дархан-Эрдэнэтийн авто замаас Амарбаясгалант хийд чиглэлийн авто зам

Авто замын зурвас талбайд 15.0 м гүнтэй, 7 цооног, 4.0-6.0 м гүнтэй, 63 цооног өрөмдсөн. Судалгааны талбайд нийт 367.0 уртааш метр өрөмдлөгийн ажил гүйцэтгэж, буурь хөрсний физик-механик шинж чанарыг тодорхойлох зорилгоор 30 ширхэг дээж авч лабораторийн шинжилгээг “Ганхошуу” ХХК-ийн инженер А.Назгүл, О.Нарангуа, Э.Энхжин нар хийж гүйцэтгэсэн байна. Авто замын итгэмжлэгдсэн "Лабо" ХХК-ийн лабораторид карьерийн материалд зориулж 4 дээжинд шинжилгээг хийлгэсэн болно. Хөрсний усны 2 дээжийн шинжилгээг Геоэкологийн хүрээлэнд тус тус хийлгэсэн байна.

Дархан-Эрдэнэтийн засмал замаас Сант сум чиглэлийн авто зам

Авто замын зурвас талбайд 15.0 м гүнтэй, 2 цооног, 4.0 м гүнтэй, 35 цооног өрөмдсөн. Судалгааны талбайд нийт 170.0 уртааш метр өрөмдлөгийн ажил гүйцэтгэж, буурь хөрсний физик-механик шинж чанарыг тодорхойлох зорилгоор 36 ширхэг дээж авч лабораторийн шинжилгээг хийж гүйцэтгэсэн байна. Карьерийн материалд зориулж 2 дээжинд шинжилгээг хийлгэсэн болно.

Дархан-Эрдэнэтийн авто замаас Орхон сум чиглэлийн авто зам

Авто замын зурвас талбайд 4.0 м гүнтэй, 7 цооног нийт 28.0 уртааш метр өрөмдлөгийн ажил гүйцэтгэж, буурь хөрсний физик-механик шинж чанарыг тодорхойлох зорилгоор 17 ширхэг дээж авч лабораторийн шинжилгээг хийж гүйцэтгэсэн байна. Карьерийн материалд зориулж 2 дээжинд шинжилгээг хийлгэсэн болно.

4.3 ГЕОЛОГИЙН ТОГТОЦ

Дархан-Эрдэнэтийн авто замаас Амарбаясгалант хийд чиглэлийн авто зам

Судалгааны районд геологи, гарал үүслийн 4 хурдас, чулуулгийг ангилан авч үзлээ. Үүнд:

- а) Гуравдагч-дөрөвдөгч (Q_{III-IV})-ийн настай, аллюви-пролювийн гаралтай хурдас
- б) Уул, толгод хоорондын хөндий, бэл хормойн хурдас
- в) Палеозой (Pz)-н настай элсэн чулуу
- г) Дунд, дээд Палеозой (Pz_{2-3})-н настай хурдас

Дархан-Эрдэнэтийн засмал замаас Сант сум чиглэлийн авто зам

- а) Гуравдагч-дөрөвдөгч (Q_{III-IV})-ийн настай, делюви-пролювийн гаралтай хурдас :
- б) Орхон голын хөндийгөөр өргөн тархасан Гуравдагч-дөрөвдөгч ($Q3-4$)-ийн настай, аллюви-пролювийн гаралтай хурдас
- в) Палеозой (Pz)-н настай элсэн чулуу

Дархан-Эрдэнэтийн засмал замаас Орхон сум чиглэлийн авто зам

- а) Гуравдагч-дөрөвдөгч (Q_{III-IV})-ийн настай, делюви-пролювийн гаралтай хурдас :
- б) Палеозой (Pz)-н настай тунамал гаралтай элсэн чулуу

4.4 ГИДРОГЕОЛОГИЙН НӨХЦӨЛ

Дархан-Эрдэнэтийн авто замаас Амарбаясгалант хийд чиглэлийн авто зам

Шинээр барихаар төлөвлөж буй авто замын районд гидрогеологийн 3 уст давхарга тархсан байна. Үүнд:

- а. Голуудын хөндийн аллювийн хурдасны аллюви-пролювийн гаралтай уст давхарга
- б. Делюви-пролювийн хурдасны уст давхарга:
- в. Чулуулгийн ан цавын ус:

Дархан-Эрдэнэтийн засмал замаас Сант сум чиглэлийн авто зам

Судалгааны талбай орчинд гидрогеологийн 2 уст давхарга ангилагдана. Үүнд:

- а. Уулын бэл хормойн делюви-пролювийн хурдасанд төрөл бүрийн ширхэгтэй элсэн хөрсний үеийг даган хөрсний ус хуралддаг бөгөөд делюви-пролювийн гаралтай уст давхарга
- 2. Орхон голын аллюви-пролювийн уст давхарга нь сумын урд хэсэгт Орхон голын хөндийн тохойрсон хэсэгт агуулагдах бөгөөд хөрсний ус нь Орхон голын устай гидрваллик холбоотой, харилцан бие биеэ тэжээдэг уст давхарга

Дархан-Эрдэнэтийн засмал замаас Орхон сум чиглэлийн авто зам

Судалгааны талбайд өрөмдсөн цооногуудаас хөрсний ус болон ан цавын ус илрээгүй. Судалгааны талбайн баруун талаар Орхон голын хөндийд аллюви-пролювийн уст давхарга өргөн тархсан.

4.5 ФИЗИК-ГЕОЛОГИЙГ ҮЗЭГДЭЛ, ҮЙЛ ЯВЦ

Дархан-Эрдэнэтийн авто замаас Амарбаясгалант хийд чиглэлийн авто зам

Авто замын трассын зарим хэсэг нь уулын хажуу, бэл хормойгоор үргэлжилж байгаа учраас бороо, хуртай үед газрын хэвгий дагаж, гадаргуугийн ус буух өндөр магадлалтай тул ус зайлуулах арга хэмжээг авах хэрэгтэй юм. Устай-Зүүний гол гатлаж байгаа хэсэгт шаварлаг хөрс 0.8-0.9 м-ийн зузаантай тархсан. Намгархаг гадаргуутай, дов сондуултай, газрын гадаргууд хүйтний хагарал янз бүрийн хэлбэр хэмжээтэй үүссэн байгаа нь шаварлаг хөрс хөлдөхдөө хүчтэй овойлт үүсгэхийг харуулж байна. Мөн Еэвэн голын хөндийн зарим хэсэгт шаварлаг хөрс зузаан тархсан, бага зэргийн дов сондуул үүссэн, намгархаг гадаргуутай байгааг анхаарах нь зүйтэй.

Дархан-Эрдэнэтийн засмал замаас Сант сум чиглэлийн авто зам

1. Авто замын трасс нь Орхон голын гүүр гараад баруунаасаа зүүн тийш хэвгий тогтоцтой уулын бэл хормойгоор үргэлжилж байгаагаас бороо хуртай үед газрын хэвгий дагаж, гадаргуугийн угаагдал явагдаж, авто замд сөрөг нөлөө үзүүлэх өндөр магадлалтайг анхаарах нь зүйтэй.

2. Сумын төвийн доторхи замын трассд шаварлаг хөрс харилцан адилгүй зузаантай тархсан, дээрхи хөрсийг зайлуулж том хэмхдэс хөрсөөр солих арга хэмжээ авах нь зүйтэй.

3. Судалгааны талбайд тоосорхог элсэн болон шаварлаг хөрс ихээхэн тархсан нь авто замд сөрөгөөр нөлөөлөх тул гадаргуугийн уснаас сайтар хамгаалах /суваг, хоолой/ г.м арга хэмжээг авах нь зүйтэй.

Дархан-Эрдэнэтийн засмал замаас Орхон сум чиглэлийн авто зам

Судалгааны талбайд тодорхой илэрсэн геологийн үзэгдэл, үйл явц байхгүй. Харин бороо, хуртай саруудад газрын хэвгийг дагаж талбайн угаагдал явагдах нөхцөлтэй.

4.6 ДУГНЭЛТ БА ЗӨВЛӨМЖ

1. Авто замын зурвас талбай нь инженер-геологийн дунд зэргийн төвөгтэй нөхцөлтэй талбайд ангилагдана.
2. Авто замын зурвас талбайд тархсан хөрсний газар шорооны ажлын зэрэг болон овойлтын хүчийг IV-1 дугаар хүснэгтэд үзүүлэв.

Хүснэгт IV-1

Дархан-Эрдэнэтийн авто замаас Амарбаясгалант хийд чиглэлийн авто зам			
ИГЭ	Хөрсний төрөл	Газар шорооны ажлын зэрэг	Овойлтын хүч
1	Элсэн чигжээстэй хайр, хайрган хөрс	IV	-
2	Элсэнцэр чигжээстэй хайр, хайрган хөрс	IV	Сулавтар хүчтэй
3	Хайргархаг шавранцар хөрс	II	Хүчтэй
4	Элсэн чулуу	VI/VII	-
5	Боржин	VI/VII	-

Дархан-Эрдэнэтийн засмал замаас Сант сум чиглэлийн авто зам			
ИГЭ	Хөрсний төрөл	Газар шорооны ажлын зэрэг	Овойлтын хүч
1	Тоосорхог элсэн хөрс	I	-
2	Элсэн чигжээстэй сайр, сайрган хөрс	IV	-
3	Элсэнцэр хөрс	I	Сулавтар хүчтэй
4	Элсэнцэр чигжээстэй хайр, хайрган хөрс	IV	Сулавтар хүчтэй
5	Хайргархаг шавранцар хөрс	II	Хүчтэй
6	Шавранцар чигжээстэй хайр, хайрган хөрс	IV	Хүчтэй
7	Элсэн чулуу	VI/VII	-

Дархан-Эрдэнэтийн авто замаас Орхон сум чиглэлийн авто зам			
ИГЭ	Хөрсний төрөл	Газар шорооны ажлын зэрэг	Овойлтын хүч
1	Хайрга агуулсан элсэн хөрс	I	-
2	Хайрга агуулсан шавранцар хөрс	II	Хүчтэй
3	Шавранцар чигжээстэй хайр, хайрган хөрс	IV	Хүчтэй
4	Элсэн чулуу	V/VII	-

3. Авто замын зурвас талбайд тархасан буурь хөрсний механик шинж чанарын норматив үзүүлэлтийг IV-2 дугаар хүснэгтэд үзүүлэв.

Хүснэгт IV-2

Дархан-Эрдэнэтийн авто замаас Амарбаясгалант хийд чиглэлийн авто зам						
Хөрсний төрөл	Эзлэхүүн жин	Дотоод үрэлтийн өнцөг		Зууралдлын хүч		Хэв гажилтын Модуль
	Үзэ	φ^I	φ^{II}	C^I	C^{II}	E^H
	г/см ³	градус		кПа		МПа
Элсэн чигжээстэй хайр, хайрган хөрс	2.19	36	40	1.3	2	45
Элсэнцэр чигжээстэй хайр, хайрган хөрс	2.19	38	44	4	6	44
Хайргархаг шавранцар хөрс	2.17	18	21	30	45	31

Дархан-Эрдэнэтийн засмал замаас Сант сум чиглэлийн авто зам						
Хөрсний төрөл	Эзлэхүүн жин	Дотоод үрэлтийн өнцөг		Зууралдлын хүч		Хэв гажилтын Модуль
	Үзэ	φ^I	φ^{II}	C^I	C^{II}	E^H
	г/см ³	градус		кПа		МПа
Тоосорхог элсэн хөрс	1.70	27	30	3	4	18
Элсэн чигжээстэй сайр, сайрган хөрс	2.20	36	40	1.33	2	45
Элсэнцэр хөрс	1.79	21	24	9	13	10
Элсэнцэр чигжээстэй хайр, хайрган хөрс	2.25	38	44	11	17	42
Хайргархаг шавранцар хөрс	2.12	22	25	31	47	33
Шавранцар чигжээстэй хайр, хайрган хөрс	2.10	35	40	17	26	39

Дархан-Эрдэнэтийн авто замаас Орхон сум чиглэлийн авто зам						
Хөрсний төрөл	Эзлэхүүн жин	Дотоод үрэлтийн өнцөг		Зууралдлын хүч		Хэв гажилтын Модуль
	Үзэ	φ^I	φ^{II}	C^I	C^{II}	E^H
	г/см ³	градус		кПа		МПа
Хайрга агуулсан элсэн хөрс	1.85	27	30	1.3	2	28
Хайрга агуулсан шавранцар хөрс	2.14	18	21	30	45	31
Шавранцар чигжээстэй хайр, хайрган хөрс	2.18	35	40	17	26	38

Элсэн чулуу:

Эзлэхүүн жин, г/см³:

- өгөршөөгүй 2.67

- өгөршсөн 2.37

Өгөршлийн зэрэг 0.88

Хатуулаг:

- өгөршөөгүй VII (Өрөмдлөг, тэсэлгээний аргаар малтана)

- өгөршсөн VI (Хийн цохилтод төхөөрөмжөөр сулруулж малтана)

Нэгэн чиглэлийн шахагдалд үзүүлэх түр зуурын эсэргүүцэл, кгс/см² R₀= 5.0 кгс/см²

Боржин чулуу:

Эзлэхүүн жин, г/см³:

- өгөршөөгүй 2.74

- өгөршсөн 2.54

Өгөршлийн зэрэг 0.92

Хатуулаг:

- өгөршөөгүй VII (Өрөмдлөг, тэсэлгээний аргаар малтана)

- өгөршсөн VI (Хийн цохилтод төхөөрөмжөөр сулруулж малтана)

Нэгэн чиглэлийн шахагдалд үзүүлэх түр зуурын эсэргүүцэл, кгс/см² R₀= 5.0 кгс/см²

4. Авто замын зурвас талбайд тархасан хөрсний улирлын хөлдөлтийн норматив гүн, м:

Баруунбүрэн станцаар:

- Шавар, шавранцар хөрсөнд 2.45 м

- Элсэнцэр, жижиг ширхэгтэй хөрсөнд 2.98 м

- Том ширхэгтэй элсэн хөрсөнд 3.15 м

- Том хэмжээст хөрсөнд 3.50 м

Орхон станцаар:

- Шавар, шавранцар хөрсөнд 2.61 м

- Элсэнцэр, жижиг ширхэгтэй хөрсөнд 3.17 м

- Том ширхэгтэй элсэн хөрсөнд 3.36 м

- Том хэмжээст хөрсөнд 3.73 м

Хадан хөрс илэрсэн тохиолдолд хадан хөрсний дээд хилээр тооцох

5. Авто замын зурвас талбайд тархасан хөрсний хувийн цахилгаан эсэргүүцэл /Ом.м/:

- Элсэн чигжээстэй хайр, хайрган хөрс - 650-730

- Элсэнцэр чигжээстэй хайр, хайрган хөрс - 280-350

- Хайргархаг шавранцар хөрс - 32-40

- Элсэн чулуу - 180-280

- Боржин - 270-400

- Хайрга агуулсан элсэн хөрс - 600-650

- Хайрга агуулсан шавранцар хөрс - 32-40

- Шавранцар чигжээстэй хайр, хайрган хөрс - 180-280

- Элсэн чулууны хүчтэй өгөршил - 180-280

6. Судалгааны районд газар хөдлөлтийн T₂ баллын бүсэд хамаарна.

Дархан-Эрдэнэтийн засмал замаас Сант сум, Орхон сум чиглэлийн авто замын инженер геологийн зөвлөмж:

Авто замын трассын зарим хэсэг нь уулын хажуу, бэл хормойгоор үргэлжилж байгаа учраас бороо, хуртай үед газрын хэвгий дагаж, гадаргуугийн ус буух өндөр магадлалтай тул ус зайлуулах арга хэмжээг авах хэрэгтэй юм. Устай-Зүүний гол гатлаж байгаа хэсэгт шаварлаг хөрс 0.8-0.9 м-ийн зузаантай тархасан. Намгархаг гадаргуутай, дов сондуултай, газрын гадаргууд хүйтний хагарал янз бүрийн хэлбэр хэмжээтэй үүссэн байгаа нь шаварлаг хөрс хөлдөхдөө хүчтэй овойлт үүсгэхийг харуулж байна. Мөн Еэвэн голын хөндийн зарим хэсэгт шаварлаг хөрс зузаантай тархасан, бага зэргийн

Дархан-Эрдэнэтийн засмал замаас Сант сум, Орхон сум чиглэлийн авто замын инженер геологийн зөвлөмж:

Судалгааны талбайд салхины гаралтай тоосорхог элсэн хөрс тархасан. Тоосорхог элсэн хөрс нь ус, чийг авахаараа эзэлхүүн жингээ багасгаж, суулт үүсгэдэг онцлогтой юм. Суулт нь I төрөлд хамаарагдах бөгөөд уг хөрсөнд суурийн ажлыг явуулахдаа чийгтэй нягтруулалтыг маш сайн хийх шаардлагатай. Ус чийг авсан нөхцөлд тухайн хөрсний даацын чанар нь муудаж суулт үүсгэх шинж чанартай тул хөрс хуулалтын ажил явуулахдаа тухайн хөрсөнд ус, чийг орохоос сэргийлэх нь зүйтэй. Авто замын трасс нь Орхон голын гүүр гараад баруунаасаа зүүн тийш хэвгий тогтоцтой уулын бэл хормойгоор үргэлжилж байгаагаас бороо хуртай үед газрын хэвгий дагаж, гадаргуугийн угаагдал явагдаж, авто замд сөрөг нөлөө үзүүлэх өндөр магадлалтайг анхаарах нь зүйтэй. Сумын төвийн доторхи замын трассд шаварлаг хөрс харилцан адилгүй зузаантай тархасан, дээрхи хөрсийг зайлуулж том хэмхдэс хөрсөөр солих арга хэмжээ авах нь зүйтэй.

БҮЛЭГ-5. УС ЗҮЙН СУДАЛГАА

Судалгаанд хамрагдаж буй замын зурвас хэсэг нь Хойт мөсөн далайн цутгал голуудын ай савд орших бөгөөд байнгын урсгалт Еэвэн гол болон хаврын шар усны болон зуны хур борооны үерийн үед урсацтай болдог хуурай сайр жалга, хөндийг хөндлөн гарах ба эдгээр нь ус зүйн хувьд урьд өмнө судлагдаж байгаагүй болно.

Хээрийн судалгааны явцад замын зурвасыг байр зүйн зурагт буулгаж, сайр жалгын огтолж байгаа цэгүүдийг байршуулж, ус хураах талбайн ерөнхий байдал /ургамалшилт, хөрсний бүтэц, ус хураах талбайн өргөн, урт болон голдиролын тахиршилт, эргийн байдал зэрэг/-ын бичиглэл хийлээ.


Судалгаанд хамрагдаж байгаа замын хэсгийн төлөвлөж буй ус өнгөрөөх барилгуудын ус хураах талбайн сав газрын гидрографийн үзүүлэлт /ус хураах талбайн хэмжээ, дундаж өндөр, хэвгий болон сайр жалгын урт, дундаж хэвгий, тахиршилт/-ийг М1:100000 масштаб бүхий байр зүйн зураг ашиглан тодорхойлов.

Еэвэн гол: Бүрэнгийн нурууны салбар Их Зол уулын ар бэлийн болон Ар Мандалын нурууны ар бэлийн ой мод ихтэй хэсгээс эх авдаг жижиг голууд нийлж Еэвэн гол нэрийг авч 40,5км урсаад Орхон голын зүүн гарт цутгана. Голын усны урсацын үндсэн тэжээл нь хур борооны ус байх боловч ул хөрсний болон цас мөсний усны тэжээл чухал суурь эзэлнэ. Жилийн урсацын бүх тэжээлийн 50-60 хувийг хур борооны ус, 15-25 хувийг ул хөрсний ус, мөн ийм хэмжээний усыг цас, мөсний ус тус тус өгдөг ажээ. Усны тэжээлд эзлэх цас, мөсний усны хэмжээ уруудах тусам нэмэгдэнэ. Гол нийт 884,0км² талбайгаас усжих урсах явцад Хүжийн гол, Тээлийн гол, Устай зувч гол болон хэд хэдэн булаг цутгадаг. Гулдирал ихээхэн тахирлахаас гадна билчирээс доош хэд хэд салаалж арал, салаа татуургууд үүсгэнэ. Голын өргөн харилцан адилгүй боловч эхэндээ ихэвчлэн 3-10 метр байснаа адагтаа 20-50 метр хүртэл өргөсдөг.



Зураг 5-1.Еэвэн голын ус хураах талбайн тойм зураг


Хүжийн гол: Бүрэнгийн нурууны салбар Гэсгүй овоо уулын ар бэлийн ой мод ихтэй хэсгээс эх авдаг булгууд нийлж Хүжийн гол нэрийг авч 14,5км урсаад Еэвэн голын баруун гарт цутгана. Голын усны урсацын үндсэн тэжээл нь хур борооны ус байх боловч ул хөрсний болон цас мөсний усны тэжээл чухал суурь эзэлнэ. Жилийн урсацын бүх тэжээлийн 50-60 хувийг хур борооны ус, 15-25 хувийг ул хөрсний ус, мөн ийм хэмжээний усыг цас, мөсний ус тус тус өгдөг ажээ. Усны тэжээлд эзлэх цас, мөсний усны хэмжээ уруудах тусам нэмэгдэнэ. Гол нийт 41,0км² талбайгаас усжих урсах явцад хэд хэдэн булаг цутгадаг. Гулдирал ихээхэн тахирлахаас гадна билчирээс доош хэд хэд салаалж арал, салаа татуургууд үүсгэнэ. Голын өргөн харилцан адилгүй боловч эхэндээ ихэвчлэн 3-5 метр байснаа адагтаа 5-10 метр хүртэл өргөсдөг. Хавар голын татамд хаврын шар усны нөлөөгөөр ихээхэн хэмжээтэй халиа үүсдэг.



Зураг 5-2.Хүжийн голын ус хураах талбайн тойм зураг

Уст зуувчийн гол: Бүрэнгийн нурууны салбар Дархийн овоо уулын ар бэлийн ой мод ихтэй хэсгээс эх авдаг жижиг голууд нийлж Еэвэн гол нэрийг авч 17,0км урсаад Еэвэн голын баруун гарт цутгана. Голын усны урсацын үндсэн тэжээл нь хур борооны ус байх боловч ул хөрсний болон цас мөсний усны тэжээл чухал суурь эзэлнэ. Жилийн урсацын бүх тэжээлийн 50-60 хувийг хур борооны ус, 15-25 хувийг ул хөрсний ус, мөн ийм хэмжээний усыг цас, мөсний ус тус тус өгдөг ажээ. Усны тэжээлд эзлэх цас, мөсний усны хэмжээ уруудах тусам нэмэгдэнэ.

Гол нийт 69,0км² талбайгаас усжих урсах явцад хэд хэдэн булаг цутгадаг. Гулдирал ихээхэн тахирлахаас гадна билчирээс доош хэд хэд салаалж арал, салаа татуургууд үүсгэнэ. Голын өргөн харилцан адилгүй боловч эхэндээ ихэвчлэн 3-10 метр байснаа адагтаа 20-50 метр хүртэл өргөсдөг.



Зураг 5-3.Уст зуувчийн голын ус хураах талбайн тойм зураг

Хамгийн их урсацын тооцоо

Еэвэн голын аль ч хэсэгт хур борооны үер шар усны үерээс олон дахин их хэмжээтэй ажиглагддаг, учир нь голын усны үндсэн тэжээл хур борооны ус юм. Хаврын шар усны үер 4-р сарын сүүлчээс эхлэн ажиглагдах бөгөөд ихэвчлэн 25-30 хоног үргэлжилдэг. Хаврын шар усны үерийн хэмжээ нь эхэн хэсэгтээ жилийн нийт урсацын 8-10%, харин төгсгөл хэсэгтээ 12-15%-ийг эзэлдэг. Зуны хур борооны үер нь голын эхэн ба дунд хэсэгт 6-р сарын сүүлчээр, адагт 7-р сарын эхний хоногт ихэвчлэн эхлэн 8-р сарын сүүлч хүртэл ажиглагддаг. Энэ хугацаандаа 2-3 удаа үер давтагдан ажиглагддаг. Тухайн сав газар нь Монгол орны уруйн үер /дунд зэрэг/ болж өнгөрдөг мужид хамаарагдах бөгөөд богино хугацаанд эрчимтэй орсон борооны улмаас их хурдтай үер бууж ирдэг онцлогтой.

Хүснэгт 5-2: Янз бүрийн хангамж бүхий их урсацын үзүүлэлтүүд

Хөндлүүр	Ус хураах талбай /км ² /	Олон жилийн дундаж				Янз бүрийн хангамж бүхий их урсац Q /м ³ /сек/		
		Урсац Q /м ³ /сек/	Модуль M /л/сек км ² /	Хувьслын коэффициент		1%	2%	5%
				Cv	Cs			
Амарбаяс-галант <i>/Еэвэн гол/</i>	121,32	4,18	0,28	0,73	1,5 Cv	42.430	37.338	30.550
Сант сум <i>/Еэвэн гол/</i>	995.72	11,4	0,16	0,73	1,5 Cv	121.875	107.25	87.74
Амарбаяс-галант <i>/Хүжийн гол/</i>	41,18			0,73	1,5 Cv	15.072	13.264	10.852
Амарбаяс-галант <i>/Уст зуувч гол/</i>	69,50			0,73	1,5 Cv	21.149	18.611	15.227
Орхон сум <i>/хуурай сайр/</i>	9,39					7.985	7.026	5.749

Голын усны түвшний байдал

Еэвэн голын усны түвшин голын урсацын нэгэн адил хавар цас мөсний хайлбар ус урсах үед огцом нэмэгдэж огцом буурч харин хур бороо орж урсац нэмэгдэх үе хүртэл хамгийн бага хэмжээтэй болдог. Зуны хур борооны үерийн үед хэд хэд дахин их утгаа авч нэмэгддэг. Энэ үед хур борооны эрчимшилтээс шалтгаалж хэмжээ, хугацаа нь янз бүр байдаг. Үүний дараа усны түвшин аажмаар буурч өвлийн хамгийн бага түвшин хүрнэ. Тухай судалгааны хөндлүүрт тохиох янз бүрийн хангамж бүхий усны түвшинг үзүүлбэл:

- Амарбаясгалантын гүүрийн хөндлүүр дээр $Q_{1\%} = 42,43\text{м}^3/\text{сек}$
- Сантын гүүрийн хөндлүүр дээр $Q_{1\%} = 121,87\text{м}^3/\text{сек}$

Автозамын ус өнгөрүүлэх байгууламжийн усзүйн судалгааны тайлангаас дэлгэрэнгүй үзэх.

БҮЛЭГ-6. ХЭЭРИЙН ХАЙГУУЛ СУДАЛГААНЫ АЖИЛ

Төслийн хайгуул судалгааны ажлыг цуваа аргаар гүйцэтгэхэд доор дурдсан багууд ажилласан. Үүнд:

- Трассын байршлыг сонгож тогтоох “RCSC”ХХК баг.
- Трассын гадаслагаа болон бэхэлгээ хийх “RCSC”ХХК баг.
- Геодезийн хэмжилт дэвсгэр зураг хийх “Зам сервис” ХХК, “Геотэс”ХХК баг.
- Инженер-геологийн судалгаа хийх “Ганхошуу”ХХК баг.
- Байгаль орчны төлөв байдлын үнэлгээ хийх “САТУ”ХХК баг.

Зам баригдах газар нутагт урьдчилсан ажиглалт, трасс сонголтын судалгааг 2016 оны 03 дугаар сарын 15-20 -ны хооронд “АрСиЭсСи” ХХК -ийн баг хийсэн болно. Хайгуулын баг урьдчилсан трасс сонголтыг хийхдээ М100.000 зураг дээр трассын хэд хэдэн хувилбарыг оруулан тэдгээрийг газар дээр нь явж үзэж үндсэн трассыг нарийвчлан тогтоосон. Төслийн замын трасс сонголтыг хийхдээ техникийн даалгаврыг баримтлан орон нутгийн нийгэм эдийн засгийн нөхцөл, байгаль цаг уур, хөдөлгөөний эрчим, замын зэрэглэл, авто замын төлөвлөлтийн норм стандарт, төлөвлөлтийн үзүүлэлтүүд зэрэг олон хүчин зүйлийг харгалзан үзсэн. Мөн аймаг, сумын удирдлагууд, нутгийн зарим ард иргэд, хүмүүстэй уулзан санаа бодлыг нь сонсож, тодорхой санал зөвлөмжүүдийг авсан болно. Хайгуулын баг судалгааны явцад орон нутгийн хөрс материалын онцлог, хиймэл байгууламжийн ашиглалтын байдлын судалгаа хийсэн. Замын трассыг газар дээр нь гар ажиллагаатай GPS ашиглан трассын мөрийг тэмдэглэсэн болно. GPS-ийн өгөгдөлөөр тодорхой цэгүүдийн өргөрөг, уртраг, өндрийн түвшингийн өгөгдлийг тэмдэглэлээ. Дараах өгөгдлүүдийг GPS-ээр тэмдэглэн авсан. Үүнд:

- Замын маршрутын дагуу 100м тутамд (замын зарим хэсэгт 50м тутамд) цэгийн өргөрөг, уртраг, өндрийн түвшин;
- Замын хиймэл байгууламжуудын байршил:
- Төлөвлөж буй гүүр
- Төлөвлөж буй хоолой
- Замын уулзвар болон бусад онцлог цэгүүдийн байршил;
- Аяллын хурд, огноо;

GPS-ийн бүртгэлээс гадна фото зургийг дараах цэгүүд дээр авлаа. Үүнд:

- Зурвасын дагуух замын нөхцөл байдал;
- Замын хүндрэлтэй нөхцөлтэй зарим хэсгүүд (Уруйн үер болдог газар, элс, цас хунгарладаг газар г.м);
- Шороон орд болон чулууны карьер;

Замын урьдчилсан төлөвлөлтийн шатанд дүгнэлт хийх зорилгоор хайгуул судалгааны ажлын үед дараах ажлуудыг хийж гүйцэтгэсэн. Үүнд:

- Дагуу ба хөндлөн огтлол;
- Хэвтээ ба босоо трассын геометр элементүүд;
- Хөрсний шинжилгээ;
- Тухайн орон нутгийн түгээмэл тархацтай материалыг ашиглах боломж бололцоо нөөц олдоц;
- Шинээр ашиглах боломжтой карьеруудын байршил;
- Зам барилгын үед ашиглах уст цэгийн судалгаа;
- Ус зайлуулах ба үерээс хамгаалах барилга байгууламжийн судалгаа;
- Замын уулзвар, болон үйлчилгээний газрын хэлбэр байршил
- Замын хөдөлгөөний аюулгүй байдлын хангамж
- Хучилтын хийц, гүүр, хоолой, уулзвар, гарцын төлөвлөлт, зэргийг судласан.



Зураг 6-1. Хайгуулын ажлын үеэр



Зураг 6-2. Хэмжилт зураглал хийж байгаа нь



Зураг 6-3. Инженер геологийн судалгаа хийж байгаа нь

БҮЛЭГ-7. ЗАМЫН ТРАССЫН ОДООГИЙН БАЙДАЛ

Сэлэнгэ аймгийн Орхон, Сант, Баруун бүрэн сумуудын нутагт 3 хэсэг газар зам баригдана. Замын трассыг зургийн даалгавар болон гэрээний холбогдох зүйл заалтын дагуу заасан цэгүүдийг дайруулж сонгосон бөгөөд 1-р хэсэг нь Дархан-Эрдэнэтийн замаас (49006'29.60" N, 105023'14.69"E) Орхон сумын төв (49008'43.5" N, 105023'43.61"E) хүртэл 5.0 км, 2-р хэсэг Дархан-Эрдэнэтийн замаас (49008'0.29" N, 105019'56.68"E) Сант сумын төв (49008'43.55" N, 105023'43.59"E) хүртэл 17.2 км, 3-р хэсэг Дархан-Эрдэнэтийн замаас (49008'0.29" N, 105019'56.69"E) Амарбаясгалант хийд (49015'3.23" N, 105022'46.72"E) хүртэл 33.4 км, нийт 55.6 км хатуу хучилттай авто зам баригдана.

Дархан-Эрдэнэтийн засмал замаас Орхон сум чиглэлийн авто зам

Төслийн замын трассын сонголтыг хийхдээ орон нутгийн иргэд, нийтийн тээврийн автомашинууд олон жил зорчсон одоо ашиглагдаж буй хайрган болон сайжруулсан шороон замын дагуу хийсэн ба шороон замтай зарим хэсэгт зэрэгцээ байдлаар трасс сонгосон ба шороон замыг барилгын явцад түр зам болгон ашиглах юм.

